



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 5/17.

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, ажил
хавсруулан гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.1.8, 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.2, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалт, Засгийн газрын 1996 оны 90 дүгээр тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарын аймгийн Засаг даргатай байгуулсан 2016 оны үр дүнгийн гэрээгээр хүлээсэн ажил үйлчилгээний хэрэгжилтийг үнэлсэн Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн "D" буюу "Дутагдалтай" үнэлэгдсэн Биндэр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Г.Буянтогтохын хөдөлмөрийн гэрээг 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн цуцлан үүрэгт ажлаас нь чөлөөлж, тус сургуулийн багш П.Онончимэгийг мөн өдрөөс эхлэн сургуулийн захирлыг томилогдох хүртэл захирлын үүргийг хавсруулан гүйцэтгүүлсүгэй.

2. Захирлын ажлыг хүлээлцэх комисс томилон ажиллуулахыг сумын Засаг дарга /С.Эрхэмбаяр/-д даалгасугай.

3. Г.Буянтогтохтой зохих хууль, журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусган захирлын ажлыг хавсран гүйцэтгэх П.Онончимэгт үндсэн цалингаас нь 25 хувиар тооцон нэмэгдэл хөлс олгохыг сургуулийн нягтлан бодогч /Ц.Болормаа/-д зөвшөөрсүгэй.

4. Г.Буянтогтохыг ажил хүлээлцсэн өдрөөс эхлэн ажлын байраар хангаж ажиллахыг сургуулийн захирлын үүргийг хавсран гүйцэтгэх П.Онончимэгт даалгасугай.

5. Захирлын үүргийг хавсран гүйцэтгэх П.Онончимэгийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 713